



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/351

Улаанбаатар хот

**Баянзүрх дүүргийн 251 дүгээр
цэцэрлэгийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 1,200,000.0 /нэг сая хоёр зуун мянга/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн 251 дүгээр цэцэрлэг /Г.Оюун-Эрдэнэ/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 251 дүгээр цэцэрлэг /Г.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /С.Ариунжаргал/-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001093

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 10 сарын
 14 өдрийн 01361 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 251-р цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтанд орсон	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
Тавилга, эд хогшил											
1	Номын тавиур			2019	Сайн	ш	1	150,000.00	150,000.00	Эцэг эх	Хандив
2	Хувцасны шүүгээ			2019	Сайн	ш	1	210,000.00	210,000.00		
3	Жижиг тавиур			2019	Сайн	ш	1	30,000.00	30,000.00		
4	Сургалтын тавиур			2019	Сайн	ш	1	250,000.00	250,000.00		
5	Эсгий самбар			2019	Сайн	ш	2	45,000.00	90,000.00		
6	Санхүүгийн самбар			2019	Сайн	ш	1	100,000.00	100,000.00		
7	Шилэн дансны самбар			2019	Сайн	ш	1	20,000.00	20,000.00		
Тавилга, эд хогшилын дүн							8		850,000.00		
Машин тоног төхөөрөмж											
8	Өнгөт принтер	Epson 3118		2019	Сайн	ш	1	350,000.00	350,000.00	Эцэг эх	Хандив
Машин тоног төхөөрөмжийн дүн							1		350,000.00		
Нийт хөрөнгийн дүн									1,200,000.00		